



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс
сэргийлж ажиллах тухай

Авлигатай тэмцэх газраас төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох, авлигын эрсдэлийн шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгах, авлигаас урьдчилан сэргийлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчил гарах эрсдэл үүссэнийг анхааруулсан Эрүүл мэндийн яаманн зөвлөмжийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн салбарт үүссэн авлига, ашиг сонирхлын зөрчил гарах эрсдэлийг арилгах, урьдчилан сэргийлэх, хавсралтанд заасан чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй томилосугай.


Ажлын хэсгийн ахлагч: Ц.Энхбаясгалан /ХНА-ны дарга, АТГ-ын ЭБАТ /
Гишүүд: С.Оюун-Эрдэнэ /Санхүү албаны дарга /
Т.Булгантамир /Дотоод хяналтын мэргэжилтэн/
Д.Бат-Эрдэнэ /Хүний нөөцийн ажилтан/
О.Дулмаа /Архив, бичиг хэргийн ажилтан/

2. Авлига, ашиг сонирхлын зөрчил гарах эрсдэлийг арилгах, урьдчилан сэргийлэх Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Зөвлөмжийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлийг гаргах ажлын хэсгийн ахлагч /Ц.Энхбаясгалан /-д даалгасугай.


ДАРГА

Э.БОДЬЦЭЦЭГ



3 170 7031905

Хан-Уул эрүүлт мэндийн төвийн даргын
2022 оны 06 дүгээр сарын 14-ны өдрийн
А/УС...-р тушаалын нэгдүгээр хавсралт



АВЛИГА, АШИГ СӨНИРХЛЫН ЗӨРЧИЛ ГАРАХ ЭРСДЭЛИЙГ АРИЛГАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛГЭХ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэх
1	<p>1.1. Архив, албан хэрэг, хөтлөлтийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.7-д заасны дагуу "Байгууллагын баримт нягтлан шалгах комисс"-ын үйл ажиллагааг тогтмолжуулах;</p> <p>1.2. Засгийн газрын 2020 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Монгол Улсын стандарт (МЫ5 5140-1:2021, МЫ3 5140-2:2021, МЫ3 5140-3:2021)-ыг мөрдлөг болгох;</p>	<p>Архив бичиг хэргийн ажилтан О.Дулмаа</p> <p>Архив бичиг хэргийн ажилтан О.Дулмаа</p>	<p>"Байгууллагын баримт нягтлан шалгах комисс"-ын гишүүд</p> <p>-</p>
2	<p>2.1. Албан тушаалд ажилтныг томилохдоо хууль, дүрэм журмын дагуу, сонгон шалгаруулалтыг ил тод зарлаж байх;</p> <p>2.2. Ажлын байранд тавигдах шаардлагыг хууль, дүрэм, журамд нийцүүлэн боловсруулж, мөрдөх. Тухайлбал: Байгууллагын ерөнхий, ахлах нягтлан бодогчийн албан тушаалд Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн тушаалаар батлагдсан журамд заасан шаардлага, шалгуурыг хангасан ажилтныг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны даргын албан тушаалд Монгол Улсын Шадар</p>	<p>Хүний нөөцийн алба</p> <p>Хүний нөөцийн алба</p>	<p>Мэдээлэл технологийн алба</p> <p>Бүх алба хэлтэс</p>

		<p>сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 116/А/565 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан шаардлагыг хангасан ажиглалтыг, Дотоод аудитторын албан тушаалд Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын шинэчилсэн дүрэмд заасан шалгуурыг хангасан ажиглалтыг тус тус томилох гэх мэт;</p>		
		<p>3.1. Худалдан авах ажиллагаатай холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчил гарах эрсдэлээс сэргийлэх;</p>	Санхүү алба	
		<p>3.2. Байгууллагын ажигтнуудыг худалдан авах ажиллагааны чиглэлээр сургалтад хамруулах. Зөвхөн АЗ гэрчилгээтэй ажигтныг худалдан авах ажиллагааны Үнэлгээний хороонд ажиллуулах; Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тогтмол сэлгээ хийх;</p>	Санхүү алба	Хүний нөөцийн алба
		<p>3.3. Нээлтэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийж, нэг төсөвт өртгийг хэд хэдэн хэсэгт хувааж худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байх;</p>	Санхүү алба	Эм зүйн алба, АТГ-ын ЭБАТ
3	Худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад холбогдох дүрэм, журмыг хатуу мөрдөх.	<p>3.4. Шууд болон харьцуулалтын аргаар худалдан авалт хийж болгох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлах, дээд хязгаараас давсан тохиолдолд үнийн санал авах нэрээр шууд худалдан авалт хийхгүй байх;</p>	Санхүү алба	Эм зүйн алба, АТГ-ын ЭБАТ
		<p>3.5. Намалт гэрээ байгуулахтай холбоотой хууль, журмыг хатуу мөрдлөг болгох;</p>	Санхүү алба	Эм зүйн алба, АТГ-ын ЭБАТ
		<p>3.6. Төндөрийн баримт бичгийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах;</p>	Санхүү алба	Эм зүйн алба, АТГ-ын ЭБАТ
4	Хандив, тусламж авах, захиран зарцуулахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг	<p>4.1. Хандив тусламж авахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч байх;</p>	Санхүү алба	АТГ-ын ЭБАТ

<p>сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдөх</p>	<p>4.2. Зөвшөөрөл авсны дагуу хандив, тусламж авсан тохиолдолд 2 жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахгүй, гэрээ байгуулахгүй байх;</p> <p>4.3. Хандив, тусламжаар хүлээн авсан эд хөрөнгө, бараа, материалыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журмын дагуу орлогод авах, бүртгэх, зарцуулалтыг тайлагнах;</p> <p>4.4. Байгууллагын зай талбайг түрээслэгчээс хандив, тусламж авахгүй байх.</p> <p>5.1. Тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээр худалдан авахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасныг чанд мөрдөх;</p> <p>5.2. Хууль, тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохгүй байх;</p> <p>5.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан зардлуудыг хэмнэж ажиллах;</p> <p>5.4. Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;</p> <p>5.5. Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох;</p> <p>5.6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллээс өөрийн байгууллагад хамаарах мэдээллийн ил тод байдлыг хангах;</p> <p>5.7. Шилэн дансны мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд бүрэн байршуулах.</p>	<p>Санхүү алба</p> <p>Санхүү алба</p> <p>Санхүү алба</p> <p>Санхүү алба</p> <p>Санхүү алба</p> <p>Санхүү алба</p> <p>Санхүү алба</p> <p>Санхүү алба</p> <p>Санхүү алба</p> <p>Санхүү алба</p> <p>Санхүү алба</p>	<p>АТГ-ын ЭБАТ</p> <p>АТГ-ын ЭБАТ</p> <p>АТГ-ын ЭБАТ</p> <p>АТГ-ын ЭБАТ</p> <p>АТГ-ын ЭБАТ</p> <p>АТГ-ын ЭБАТ</p> <p>АТГ-ын ЭБАТ</p> <p>АТГ-ын ЭБАТ</p> <p>АТГ-ын ЭБАТ</p> <p>АТГ-ын ЭБАТ</p> <p>АТГ-ын ЭБАТ</p> <p>АТГ-ын ЭБАТ</p>
<p>5. Төрийн хэмнэлтийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх</p>		<p>Хүний нөөцийн алба</p> <p>Санхүү алба</p> <p>Санхүү алба</p>	<p>Мэдээлэл технологийн алба</p> <p>Хүний нөөцийн алба</p> <p>АТГ-ын ЭБАТ</p>
		<p>Санхүү алба</p>	<p>АТГ-ын ЭБАТ</p>

<p>6. Байгууллагын түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхдээ, холбогдох хууль, журмыг мөрдөх</p>	<p>6.1. Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-д "Байгууллагын тэгш ойг байгуулагдсан өдрөөс хойш 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай тухайн салбарын асуудалд эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн тухайн байгууллагын удирдлага холбогдох шийдвэр гаргаж тэмдэглэнэ" гэж заасныг мөрдөх;</p> <p>6.2. Дээрх журамд түүхэн үйл явдал, ойг тэмдэглэхэд шаардагдах зардлыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, Төрийн бус байгууллагын хандив, ивээн тэтгэгчдийн хөрөнгөөр бүрдүүлж болохоор заасныг хэрэгжүүлсэн тохиолдолд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтуудыг чанд мөрдөх;</p> <p>6.3. Түүхэн үйл явдал, ойг тэмдэглэхдээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөх.</p>	<p>Санхүү алба</p> <p>Санхүү алба</p>	<p>АТГ-ын ЭБАТ</p> <p>АТГ-ын ЭБАТ</p>
		<p>Хүний нөөцийн алба</p>	<p>Санхүү алба</p>